

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Эрүүгийн
хуульд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” Мөн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэг “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно.” гэж тус тус заасан.

Монгол Улсад Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактуудаар хамгаалагдсан ардчиллын үнэт зүйл бөгөөд Монгол Улсын нэгдэн орсон холбогдох олон улсын гэрээгээр агуулга, хүрээн нь тодорхойлогдсон байдаг билээ.

НҮБ-ын хүний эрхийн механизмаас цөөнгүй зөвлөмж авсны нэг нь “гүтгэх”, “доромжлох” гэмт хэргийг Эрүүгийн хуулиас халах тухай юм. Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 2015 оны Эрүүгийн хуулиас тус гэмт хэргийг халж, Зөрчлийн тухай хуульд “гүтгэх” зөрчлийг тусгаж хоёр жил гаруй явсан ч мөн л хүний эрхийн үүднээс багагүй шүүмжлэлд өртөж, 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Зөрчлийн хуулиас тус заалтыг хасаж, Эрүүгийн хуульд “Худал мэдээлэл тараах” гэсэн гэмт хэргийг шинээр томьёолж оруулсан билээ. Шинэ Эрүүгийн хуулийг дагаж мөрдсөнөөс хойш даруй дөрвөн жил өнгөрч байна.

Сэтгүүлчдийг хамгаалах хороо Олон улсын байгууллагын мэдээгээр 2019-2023 хооронд “худал мэдээ тараах” тухай хуулийн зүйн зохицуулалтыг 91 улс шинээр бий болгосон. 2022, 2023 онд дэлхий даяар хамгийн олон сэтгүүлчдийг хорьсон байна. Монгол Улсад ч мөн Хил хязгааргүй сэтгүүлчид олон улсын байгууллага болон “Глоб Интернэшнл” зэрэг иргэний нийгмийн байгууллагуудын тайлан мэдээлэлд үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийн нөхцөл байдал дордсон. Энэ эрхийг төрийн зүгээс хязгаарласан, халдсан тохиолдлууд гарсаар байгааг анхааруулсаар байгаа билээ. Монгол Улс 2023 оноос хойш нэг жилд 21 байраар ухарсан. Харин сүүлийн найман жилд 60 байрнаас 109 хүртэл буюу 49 байраар ухарч "асуудалтай" ангилалд багтаж байна.

Улсын Их Хурал 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “худал мэдээлэл тараах” гэмт хэргийг нэмэлтээр оруулсан энэ гэмт хэрэг нь “нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан” гэж

объектив талын шинжээр тодорхойлогдсон, 2002 оны Эрүүгийн хуульд байсан “гүтгэх” гэмт хэргээс өргөн агуулга, хүрээтэй, шинэ хэв шинж бүхий гэмт хэрэг болжээ. Уг нэмэлтээр хууль тогтоогч уг гэмт хэргийг “олон нийтэд тараасан бол” гэж объектив талын шинжээр нь тодорхойлж, субъектив талын шинжийг бүрхэгдүүлэн, худал мэдээлэл нь “гутаасан, гутаах” зорилго, агуулга, шинжтэй байх эсэхийг бүрэн гүйцэд тодорхойлолгүй орхигдуулж, нэр томьёо, ойлголтын зөрүүтэй байдал үүсгэсэн.

“Энэ гэмт хэргийн хохирогчид төрийн байгууллага хамаарахгүй. Үзэл бодлоо илэрхийлэхдээ улс төрд нөлөө бүхий этгээдийг гэмт хэрэгт хардсан, сэрдсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй” гэсэн тайлбарыг хассан. Энэ нь хууль зүйн техникийг бүрэн бүрдүүлэх шаардлагыг алдагдуулан, хууль бүтээх ажиллагааны алдаа болсон буюу эрх зүйн хийдэл үүсгэсэн. Ингэснээр үг хэлэх эрх, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн байдлыг дордуулан, өнөөдөр хууль хэрэглээ, шүүхийн практикт сөрөг үр дагавар үүсгэж байгаагийн гол шалтгаан болжээ гэж үзэх үндэстэй байна.

Монгол Улсад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлд заасан “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн хүрээнд 2020 онд 251, 2021 оны эхний дөрвөн сарын байдлаар 119 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэснээс 25 хэрэгт л яллах дүгнэлт үйлджээ¹. 2020 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан 10 гэмт хэрэг хянан шийдвэрлэснээс худал мэдээлэл тараасан асуудлаар цагдаагийн байгууллагад гаргасан өргөдөл, гомдол, хэрэгсэхгүй болсон хэргийн тоо олон, харин шүүхэд шилжүүлсэн хэрэг цөөн байгаа нь анхаарал татаж байна.

Учир нь үг хэлэх эрх, нэр төртэй холбоотой иргэний хэргийн шинжтэй асуудлыг хамруулан эрүүгийн журмаар хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаа явуулж, удаан хугацаагаар шалгаж байгаа нь мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг “дарамт”-д оруулж байна гэж хэлэлцүүлэгт оролцсон оролцогчид бүгд илэрхийлж байна. Илтэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хүрээний асуудал, иргэний маргааны шинжтэй өргөдөл, гомдлыг хүлээн авахгүй байх, эрүүгийн журмаар шалгахгүй байх асуудлыг нэн даруй шийдвэрлэх нь тулгамдсан асуудал болсон байна.

---oOo---

¹ Нээлттэй нийгэм форум “Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик” судалгааны тойм 2022 он.

